



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/ВЧ

Булган сум

Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэний тухай хуулийн 359-368 дугаар зүйл, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн их хүндэтгэл болон албан ёсны арга хэмжээ, хуралдааны үндсэн хөтлөгчөөр ажиллаж буй Хөгжимт жүжгийн театрын албан хаагч Зоригоогийн Төгөлдөрт 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сар бүр 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэмэгдэл хөлс олгож, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Б.Насанжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Нэмэгдэл хөлсийг олгоход шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтээс олгохыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. ПҮРЭВ-ОЧИР